



АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/126

Эрдэнэбулган сум

Төлөвлөгөө батлах тухай

“Томуу, томуу төст өвчний харуулдан тандалтыг өргөжүүлэх, бэлэн байдал хариу арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358 дугаар, 2017 оны 346 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Томуу, томуу төст өвчний дэгдэлтээс сэргийлэх, бэлэн байдал хариу арга хэмжээг сайжруулах ажлын 2020-2021 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөний дагуу томуу, томуу төст өвчний тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган, хариу арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан, хийсэн ажлын тайланг сар бүрийн 5-ны дотор Эрүүл мэндийн газарт ирүүлж ажиллахыг Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Тушаалыг хэрэгжүүлэн ажиллахад мэргэжил арга зүй, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Эрүүл мэндийн газрын Халдварт өвчин, дархлаажуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн /Э.Бямбацогт/, Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн /Г.Ариунтуяа/ нарт тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга /Д.Алтантуяа/-д даалгасугай.

ДАРГА



Р. ГАНДИЙМАА

6512000441



Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 05 дугаар сарын 16 ны өдрийн
А/126 дугаар тушаалын хавсралт

**ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТЭЭС СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ
ЭРЧИМЖҮҮЛЭХ АЖЛЫН 2020-2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран ажиллах байгууллага	Шалгуур үзүүлэлт
Нэг. Бэлэн байдлыг хангах					
1	Эрүүл мэндийн байгууллага бүр томуу, томуу төст өвчин, амьсгалын замын халдварын дэгдэлтийн үед хариу арга хэмжээ авах бэлэн байдлыг хангах, дэгдэлтийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд ТОДОТГОЛ хийн хэрэгжүүлж ажиллах.	10 сарын 05-ны дотор	НЭ, Сум, өрхийн ЭМТ	ЭМГ	Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөө
2	Эрүүл мэндийн байгууллага дээр үйлчлүүлэгсдийн гар халдваргүйжүүлэх, угаах нөхцлийг бүрдүүлэх	10-р сарын 5-ны дотор	НЭ, Сум, өрхийн ЭМТ	-	Гар халдваргүйжүүлэх, угаах нөхцлийг бүрдүүлсэн байдал
3	Байгууллагынхаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдыг дэгдэлтийн үед нэмэлтээр ажиллуулах хуваарь гаргах.	10 сарын 10-ны дотор	НЭ, Сум, өрхийн ЭМТ	-	Дэгдэлтийн үед нэмэлтээр ажиллуулах ажилчдын хуваарь
4	Томуу томуу төст өвчний дэгдэлтийн үед гаднаас татан ажиллуулах эмч эмнэлгийн ажилтнуудын судалгаа, гэрийн хаяг утасны дугаарын жагсаалтыг шинээр гарган мэдээлэл өгч ажиллах.	11 сарын 01-ны дотор	НЭ, Сум, өрхийн ЭМТ	ЭМГ	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын судалгаа, дайчлагдах ажиллах хуваарь
5	Томуу, томуу төст өвчин, амьсгалын замын халдварын дэгдэлтийн үед эмнэлгийн тусламж үйлчилгээ, амьсгалын дутагдалтай өвчтнүүдэд шаардлагатай эм бэлдмэл, вирусын эсрэг эм, дархлаа дэмжих эмийн нөөцийг бүрдүүлэх.	11 сарын 01-ны дотор	НЭ, сумын ЭМТ	ЭМГ, Эм холбоо	Эмийн нөөцийн судалгаа, хангалт
6	Амбулаторийн үзлэгт томуу, томуу төст өвчний эзлэх хувиас хамаарч орны зохицуулалт хийж ор нэмэх, дэлгэх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх.	11 сарын 01-ээс	НЭ, сумын ЭМТ	ЭМГ	Ор нэмэх, дэлгэх төлөвлөгөө
7	Томуу томуу төст өвчний дэгдэлтийн үед тусламж үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, багаж	10 сарын 30-ны	НЭ, сумын ЭМТ	ЭМГ	Гаргасан судалгаа, бүрдүүлсэн нөөцийн

	тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгслийн хангалтын судалгааг гаргаж, нөөцийг бүрдүүлэх.	дотор			хэмжээ
8	ТТӨ-ий улиралд вирус илрүүлэх сорьц тээвэрлэх болон бактериологи лабораторийн бэлэн байдлыг хангаж оношилур урвалжийн нөөцийг нэмэгдүүлэх	10 сарын 15-ны дотор	НЭ, сумын ЭМТ		Урвалж оношилурын хангалтын хувь
9	Томуу, томуу төст өвчний хүндэрсэн, онош тодруулах шаардлагатай тохиолдлуудаас лабораторийн шинжлэгдэхүүнийг зааврын дагуу авч үндэсний лавлагаа лабораторит хүргүүлэх	10 сарын 15-аас	НЭ, Сумын ЭМТ-ийн дарга нар	ЭМГ	Хүргүүлсэн сорьцын тоо
10	Сум, Өрхийн ЭМТ-үүдэд шинээр ажилд орсон эмч нарт ТТӨ-ий тархалтын үед баримтлах оношилгоо, эмчилгээний удирдамж болон ХӨЦМ-өөр сургалт зохион байгуулах	10 сард	Нэгдсэн эмнэлэг	ЭМГ	Сургалтанд хамрагдсан эмч нарын тоо
11	ХӨСҮТ-тэй хамтарч эрсдэлийн үнэлгээг үе шат бүрт хийх, хариу арга хэмжээг зохион байгуулах	Тухай бүрт	ЭМГ, НЭ	ХӨСҮТ, ЭХЭМҮТ	Эрсдэлийн үнэлгээ хийн хариу арга хэмжээг тухай бүр зохион байгуулсан байна
Хоёр. Дэгдэлтийн үеийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр					
1	Өрх, сумын ЭМТ-үүд жирэмсэн эх, нярай, 0-5 насны хүүхэд, эрсдэлт бүлгийн хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээ, гэрийн идэвхитэй эргэлт, хяналтанд онцгой анхаарч тусламж үйлчилгээг эрчимжүүлэх	11 сарын 01 –ээс	Сум, өрхийн ЭМТ	ЭМГ	Эх хүүхдийн 7 хоногийн мэдээ, тусламж үйлчилгээтэй холбоотой хожимдол, гомдлын тоо
2	ТТӨ, амьсгалын замын бусад халдварын дэгдэлтийн үед эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага дээр хүн амын хэт бөөгнөрөл үүсэхээс сэргийлж гэрийн үзлэг, эргэлтийг нэмэгдүүлэх	11 сараас	НЭ, Сум, Өрхийн ЭМТ	-	7 хоногийн эх хүүхдийн эргэлт хийсэн мэдээ
3	Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн дархлааг дэмжих, аминдэмжүүлэх ажил зохион байгуулах.	11 сарын 1-ээс	НЭ, Сум Өрхийн ЭМТ	-	Дархлаа дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан эмч ажилчдын тоо
4	ТТӨ-ий дэгдэлт, амьсгалын замын бусад халдварын үед өвчтөнд эмнэлгийн тусламж үйлчилгээг хугацаа алдалгүй шуурхай үзүүлэх, нэмэлтээр түргэн тусламжийн автомашин, эмч ажиллуулах, амбулаторийн үзлэгийг уртасгасан цагт шилжүүлэх	11 сарын 15-аас	НЭ, Сум, Өрхийн ЭМТ	-	Хожимдол, тусламж үйлчилгээтэй холбоотой хүндрэл гараагүй байх
5	Эрүүл мэндийн байгууллагын халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулах, амьсгалын замын халдварын үед баримтлах дэглэмийг чанд сахих	11 сараас	НЭ, сумын ЭМТ	ЭМГ	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гараагүй байх.

6	Харьяа нутаг дэвсгэрийн сургууль цэцэрлэгийн хүүхдийн ирцэнд тандалт хийж хариу арга хэмжээг тухай бүр шуурхай зохион байгуулах	10 сарын 1-ээс	ЭМГ, сум, өрхийн ЭМТ	БСУГ, ЕБС, цэцэрлэг	Ирцийн мэдээ, зохион байгуулсан ажил
Гурав. ТТӨ-ий дэгдэлтээс урьдчилан сэргийлэх					
1	Байгууллагын цахим хуудас, орон нутгийн хэвлэл мэдээллийн бүх хэрэгслийг ашиглан иргэдэд зориулан ТТӨ, амьсгалын замын халдвараас сэргийлэх талаар мэдээ, мэдээлэл, сургалт сурталчилгааг өргөнөөр зохион байгуулах.	10 сараас	ЭМГ, НЭ, сум өрхийн ЭМТ	Хэвлэл мэдээллийн байгууллагууд	Мэдээлэл, сургалт сурталчилгаа хийсэн тоо, хамрагдсан хүний тоо
2	ТТӨ-өөс урьдчилан сэргийлэх, амьсгалын замын халдварын үед эцэг, эхчүүдэд бага насны хүүхдийн гэрийн асаргаа, сувилгаа, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж хэрхэн авах талаарх мэдлэг олгох сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлэх.	10 сарын 01-ээс	НЭ, сум, өрхийн ЭМТ	ЭМГ	Мэдээлэл, сургалт сурталчилгаа хийсэн тоо, хамрагдсан хүний тоо
3	Хүүхдийн байгууллагад тодорхой давтамжтайгаар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх, зөвлөгөө өгөх	10 сарын 30-аас	НЭ, сум, өрхийн ЭМТ	ЭМГ	Үзлэг хийсэн хүүхдийн тоо
4	Томуу, томуу төст өвчний тандалтын мэдээг Өрхийн ЭМТ-үүд өдөр бүр, Сумын ЭМТ-үүд 7 хоног бүрийн даваа гаригт хугацаандаа тогтмол өгч байх.	11 сараас	НЭ, сум, өрхийн ЭМТ	ЭМГ	Мэдээ өгөлтийн хувь, хугацаандаа мэдээ ирүүлсэн байдал
5	Нэгдсэн эмнэлэг, сум дунд, сум өрх, хувийн хэвшлийн эрүүл мэндийн төвүүдэд томуу өвчний талаар эргэн мэдээлэл хийж, зөвлөмж өгч ажиллах	10 сарын 01-ээс	ЭМГ, НЭ	-	Эргэн мэдээлэл хийсэн тоо
6	Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг улирлын томуугийн вакцинаар дархлаажуулах	10 сард	НЭ, сум, өрхийн ЭМТ	ЭМГ	Вакцинд хамрагдсан эмч мэргэжилтний тоо
7	Улирлын томуугийн вакцинаар (бага насны хүүхэд, өндөр настан, жирэмсэн эмэгтэй, архаг хууч өвчтэй хүмүүс) дархлаажуулах	10 сард	Сум, өрхийн ЭМТ	ЭМГ	Вакцинд хамрагдсан иргэдийн тоо
8	Улирлын томуугийн вакцинаар хүн амыг сайн дурын дархлаажуулалтанд хамруулах ажлыг өргөнөөр зохион байгуулах	10 сарын 1-ээс 11 сарын 10-ны дотор	, Сум, өрхийн ЭМТ	ЭМГ	Вакцинд хамрагдсан иргэдийн тоо
9	Сургууль, цэцэрлэгийн хүүхдийг илчлэг амин дэмээр баялаг хоол хүнс хэрэглүүлэх, дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах	11 сарын 01-ээс	Сум, өрхийн ЭМТ	Сургууль, цэцэрлэг	Дэмжих үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн тоо

10	Зөв ханиаж найтаах, гар угаах, маск зөв тогтмол зүүх дадал хэвшүүлэх сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах	10 сарын 15-аас	ЭМГ, НЭ, Сум, өрхийн ЭМТ	Албан байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага	Сургалт нөлөөллийн ажил хийсэн давтамж, зохион байгуулсан ажлын тайлан
11	Харьяа байгууллагуудыг ТТӨ-өөс сэргийлэх зөвлөмж, мэдээллээр тогтмол хангах	10 сарын 01-ээс	Сум, Өрхийн ЭМТ	ЭМГ	Зөвлөмж мэдээллээр хангасан байгууллагын тоо
12	Эрсдэлт бүлгийн хүн амыг чийрэгжүүлэх, дархлаажуулах, нийгмийн халамжийн үйл ажиллагааг засаг захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах	11 сарын 1-ээс	Сумын ЭМТ-үүд	Албан байгууллага	витаминжуулах ажлыг зохион байгуулсан байгууллагын тоо, хамрагдсан ажилчдын тоо
13	Албан байгууллага, аж ахуй нэгжүүд ажилтнуудын биеийн байдлыг өглөө бүр хянаж ТТӨ, амьсгалын замын халдварын шинж тэмдэгтэй хүүхэд, ажилчдыг хичээл, ажлаас 7 хоног хүртэл чөлөөлж, өвчний хүндрэл бусдад халдвар тараахаас сэргийлж гэрт нь тусгаарлаж эмчлэх, эдгэрүүлэх	10 сарын 1-ээс	ЭМГ, НЭ, Сум, өрхийн ЭМТ	Албан байгууллагууд	Үзлэг хийсэн хүүхэд, ажилчдын тоо Өвчилсөн хүний тоо
14	Албан байгууллага, сургуулийн ойр орчимд ил задгай хүнс, самар сургуулийн орчинд идүүлэхгүй, худалдаалахгүй байх талаар сургалт сурталчилгаа зохион байгуулах	10 сарын 1-нээс	Сум, өрхийн ЭМТ	Албан байгууллагууд	Сургалт, сурталчилгаанд хамрагдсан хүний тоо